ОРХОН АЙМАГ

# ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 12 сарын 18 өдөр Дугаар 02/32 Жаргалант сум

Жаргалантын ногоочид хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2026 оны төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.18 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2.5 дугаар зорилтын 2.5.19 дэх заалтыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн ээлжит IV хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Жаргалантын ногоочид хөтөлбөрийн 2026 оны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган, төлөвлөгөөний биелэлтийг 2026 оны 4 дүгээр улиралд багтаан тайлагнахыг Засаг дарга (Л.Учрал)-д даалгасугай.

ДАРГА Ш.БИЛГҮҮНБААТАР

6125010060

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны
12 дугаар сарын 18-ны өдрийн ээлжит IV
хуралдааны 09/32 тогтоолын хавсралт

**ЖАРГАЛАНТЫН НОГООЧИД ХӨТӨЛБӨРИЙН 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

2025.12.10 Жаргалант сум

| № | Хөтөлбөрийн зорилт | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Үр дүнгийн үзүүлэлт | | | Санхүүжилт | | Хариуцан хэрэгжүүлэгч |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Суурь он | Суурь түвшин | Зорилтот түвшин (2026 он) | Санхүүжилт сая.төг | Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал | |
| **Зорилт 1. Төмс хүнсний ногооны үйлдвэрлэлийг механикжуулах, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, , усалгаатай тариалангийн хэмжээг нэмэгдүүлэх, хөрсний үржил шимийг сайжруулах замаар төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийг эрчимжүүлэх** | | | | | | | | | | |
| 1 | 1.1.Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчдэд нэн шаардлагатай байгаа чиргүүл, дүүжин машин, усалгааны тоног төхөөрөмж, гар | Агро үйлчилгээний техникийн засвар үйлчилгээ | Техникийн бэлэн байдал | Сая.төг | 2025 | 20.0 | 20.0 | 20.0 | ОНХС | ЗДТГ |

194

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | багажаар шат дараатай хангах | | | | | | | | | |
| **2-р зорилт: Хамгаалагдсан хөрсний тариаланг дэмжих, таримлын нэр төрлийг олшруулах, нэгж талбайгаас авах ургацыг нэмэгдүүлэх, зоорины багтаамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг дэмжих** | | | | | | | | | | |
| 2 | 2.1.Зоорины багтаамжийг нэмэгдүүлэх, сэргээн засварлахад төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хангаж ажиллах | Төмс хүнсний ногооны зоорины багтаамжийг жил тутам 40тн-оос багагүй хэмжээгээр нэмэгдүүлэх | Шинээр болон засварласан зоорины багтаамж | тонн | 2025 | 2 иргэн 105 тн багтаамжтай зоорь барьсан | 40 тн | - | Хувийн хэвшил | ЗДТГ |
| **3-р зорилт: Төмс, хүнсний ногооны үрийн чанарыг сайжруулах, хангамжийг нэмэгдүүлэх** | | | | | | | | | | |
| 3 | 3.1.Төмс, хүнсний ногооны гарал үүсэл нь тодорхой чанарын баталгаатай элит, сортын болон эрлийз үр үйлдвэрлэх, борлуулах ААН, иргэнийг дэмжих | Европ, азийн өндөр хөгжилтэй орны чанартай үр нийлүүлэгч ААН, иргэнтэй өрхийн тариаланчдыг холбож өгөх, сайн чанарын үр нийлүүлэх сувгийг нэмэгдүүлэх | 1 доошгүй иргэн,ААН | ш | 2025 | Монгол ногоо төслийн үрийн худалдаа,Экора грийн гоулд ХХК | 1 доошгүй ААН, иргэний талаар өрхийн тариаланчдад мэдээлэл өгч, хамтран ажиллаж, үр нийлүүлэх сувгийг нэмэгдүүлнэ | - | Төр хувийн хэвш-лийн хамтын ажилла-гаа | ЗДТГ |
| **4-р зорилт : Өрхийн тариаланчдыг тэргүүний ажиллагаатай ААН, тариаланчдын усалтын систем, тоног төхөөрөмжийн ашиглалт, зоорины тоног төхөөрөмжийн талаар туршлага судлах, сургаж дадлагажуулах замаар төмс, хүнсний ногооны тариалалт, үйлдвэрлэлийн шинэ технологийн мэдлэгийг дээшлүүлэх.** | | | | | | | | | | |

195

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | | Өрхийн тариаланчдыг Тариалан үйлдвэрлэлийн цахим системд ажиллахад сургах | Сургалтын тоо хамрагдсан иргэний тоо | Тоо/хүн | 2025 | Ахмадын зөвлөх үйлчил-гээг авч, сумын 50 иргэн хамрагд-сан. | Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч 50 иргэн ААН. | - | Үйл ажилла-гааны зардал | ЗДТГ |
| 5 | 4.1.Мэргэжлийн сургалтын байгууллага болон сургагч багш нартай хамтран ажиллаж, өрхийн тариаланчдыг сургалтад хамруулах | “Хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх арга замууд, ургамал хамгааллын цогц арга хэмжээ” сэдэвт сургалт зохион байгуулах | Хамрагдсан иргэдийн тоо | ш | 2025 | - | 30 | 2.5 | ОНХС | ЗДТГ |
| 6 | | Орон нутгийн тэргүүний тариаланчид, дэвшилтэт техник технологи ашиглагч өрхийн тариаланчдын хүлэмжийн | Хамрагдсан иргэний тоо | ш | 2025 | - | 15 иргэнийг хамруулна. | 0.5 | ОНХС | ЗДТГ |

196

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | аж ахуй, зоорь, усалгааны системийн тоног төхөөрөмжийн ашиглалттай танилцаж туршлага судлах | | | | | | | | |
| **Нийт төсөв: 23.0 сая төгрөг** | | | | | | | | | | |

197